

Ерөнхийлөгч Диетер
Ф.Угдорф
Тэргүүн Зөвлөлийн
Хоёрдугаар Зөвлөх



Ерөнхий чуулган — Энгийн адислал гэж байдаггүй

Сүмийн нэгэн итгэлтэй гишүүн манай сүмийн гишүүн бус хөрштэйгөө ярилцаж байжээ. Ярианы сэдэв ерөнхий чуулганы тухай эргэхэд хөрш нь түүнээс “Та нар чинь бошиглогч, төлөөлөгчидтэй гэж ярьдаг бил үү? Бас тэд жилд хоёр удаа дэлхий дахины чуулганаараа Бурханы үгсийг илчилдэг гэл үү?” гэж асуухад нь,

“Яг үнэн” гэж сүмийн гишүүн итгэлтэйгээр хариулжээ.

Хөрш хэсэг зуур энэ тухай бодолхийлэв. Түүний сонирхлыг энэ сэдэв ихэд татсан бололтой, “Өнгөрсөн ерөнхий чуулган дээр тэд юу гэж ярьсан бэ?” гэж асуув.

Яг энэ үед Сүмийн сайн гишүүн маань сайн мэдээг хуваалцахаар сэтгэл догдлон байснаа тэвдэн сандарсан гэнэ. Тэр хэчнээн ч мэрийгээд нэг ч хэлсэн үгийг санаж чадсангүй.

Найз нь түүний балмагдсаныг хараад “энэ үед Бурхан хүмүүст хандан ярьдаг гэж хэлчихээд Тэр юу гэж хэлснийг нь санахгүй байгаа юм биш биз дээ?” гэжээ.

Тэр ах үүнийг сонсоод дарууссан ажээ. Ерөнхий чуулган дээр Их Эзэний үйлчлэгчдийн хэлсэн үгсийг илүү сайн санах амлалтыг тэр өөртөө өгөв.

Ерөнхий чуулганы захиас бүрийг санана гэдэг

хүндрэлтэйг бид бүгд мэднэ. Бүгдийг санахгүй байсан ч ичиж зовох хэрэггүй гэдгийг би итгэлтэйгээр хэлж байна. Гэвч ерөнхий чуулган бүрд ялангуяа бидний хувийн амьдралын нөхцөл байдалд зориулан тэнгэрээс өгөгдсөн ямар нэгэн бэлэг мөн адислал болох захиасууд байдаг.

Ерөнхий чуулганд бэлтгэх, бидэнд хандан Их Эзэний үйлчлэгчдийн хэлсэн үгсийг илүү сайн хүлээн авч, санах болон хэрэгжүүлэх гурван үндсэн санааг би та нарт хэлье.

1. Сүмийн гишүүд ерөнхий чуулган дээр хэлсэн сүнслэг үгсийг сонсож, судлахад хувийн илчлэлт хүлээн авах онцгой боломжтой юм.

Ерөнхий чуулганд бэлтгэхдээ өөртөө тулгарсан асуултуудын хариуг авах тухай тунгаан бодохыг би уриалж байна. Жишээлбэл, магадгүй та нар тулгарсан саад бэрхшээлүүдтэйгээ холбоотой Их Эзэний заавар, зөвлөгөөг хүсч болох юм.

Та нарын онцгой залбирлуудын хариулт тодорхой нэг хэлсэн үг эсвэл нэг өгүүлбэрээс ч шууд ирж болно. Бусад үед хариултууд ямар ч хамааралгүй мэт санагдах үг, өгүүлбэр эсвэл дуунаас ирж болно. Амьдрал дахь адислалуудынхаа төлөө талархлаар дүүрэн зүрх сэтгэл, зөвлөгөө өгсөн

үгсийг сонсож, дагах чин сэтгэлийн хүсэл эрмэлзэл нь хувийн илчлэлтийг авах арга замд бэлтгэх болно.

2. Аль нэг захиасыг мэддэг юм шиг санаж, тоомсорлолгүй бүү орхи.

Бошиглогчид үргэлж давталтаар заадаг. Энэ бол сурч мэдэхүйн хууль юм. Та нар давталтыг ерөнхий чуулганы сэдвүүд болон сургаалуудаас сонсож болно. Энэ бол бүтээлч хандлага буюу сэтгэн бодох чадвар дутсан хэрэг биш гэдгийг би та бүхэнд батлан хэлж байна. Бусад зүйлсийг эхлэхийн өмнө бидний ойлгосон байвал зохих зарим зүйлс мөн үүн дээрээ тулгуурлан ажиллавал зохих мөнхийн ач холбогдолтой тулгуур зарчмуудыг Их Эзэн бидэнд зааж, бидний оюун ухаанд суулгадаг учраас бид адил төстэй асуудлуудын талаарх захиасуудыг дахин давтан сонсдог билээ. Ухаалаг барилгачин ханыг өрж, дээврийг тавихаас өмнө эхлээд суурийг нь тавьдаг шүү дээ.

3. Ерөнхий чуулган дээр хэлсэн үгс ирэх саруудын турш бидний замыг заах луужин байх ёстой.

Хэрэв бид Сүнсний өдөөлтийг сонсож, дагах юм бол энэ нь бидний өмнө байгаа үд мэдэгдэх саад бэрхшээлтэй уулс болон хөндий дундуур биднийг хөтөлж, Лиахона мэт үйлчлэх болно (1 Нифай 16-г үз).

Дэлхийн үүслээс эхлэн Бурхан хүмүүст тэдний эрин үеүдэд тэнгэрийн тааллыг ярих бошиглогчдыг дууддаг байсан. Бидэнд зориулсан Их Эзэний захиасыг сонсон, дагах нь бидний үүрэг хариуцлага мөн.

Бидний нигүүлсэнгүй, хайрт Тэнгэрлэг Эцэг хүүхдүүдээ орхиж байгаагүй мөн хэзээ ч орхихгүй. Өнгөрсөн үеийн адилаар өнөөдөр ч Тэрээр төлөөлөгчид болон бошиглогчдыг томилоод байна. Тэрбээр тэдэнд Өөрийн үгийг илчилсээр байна.

Бидний хүн нэг бүрд зориулсан Бурханы захиасыг ерөнхий чуулганаар сонсох боломжтой байх нь ямар гайхамшигтай онцгой боломж билээ! Түүний сонгогдсон үйлчлэгчдээр дамжуулан өгөгдөж буй агуу адислал болсон бурханлаг удирдамжийн төлөө сайн бэлтгэцгээе.

Энэ бол ер бусын адислал юм.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

- Захиасыг хамтдаа унш. Гэр бүлийн гишүүдээ ерөнхий чуулганаас сонсох зүйлсээ сайн ойлгоход нь урамшуулан дэмж.
- Бага насны хүүхдүүдэд Ерөнхийлөгч Угдорфын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд нь туслахын тулд Ерөнхий Эрх мэдэлтнүүдийн зургийг үзүүл (Лиахона-гийн чуулганы дугаарт байгаа). Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгынхан ерөнхий чуулган дээр үг хэлнэ гэдгийг тэдэнд ойлгуул. Хүүхдүүдийг чуулганыг сонсож, сурч мэдсэн зүйлээ санахад нь туслахын тулд зураг зурахыг урамшуулан дэмж. Эцэг эхчүүд conferencegames.lds.org –гаар орж, хүүхдэд зориулсан чуулганы үйл ажиллагаануудыг үзэж болно.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Сайн, илүү сайн, хамгийн сайн

Мари-Селесте Луис

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс 2007 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр хэлсэн үгэндээ “сайн, илүү сайн, хамгийн сайн” байх талаар ярьсан. Тэрбээр “хүүхдүүд хэт их завгүй байдаг” тухай ярих үед би буруутан мэт суудал дээрээ хавчганаж билээ.

Би дэндүү их ачаалалтай байдаг байснаа мэдэж байлаа. Би хүнд хичээлүүдийг сонгон суралцаж, сургуулийн драмын дугуйлан, бусад хэд хэдэн үйл ажиллагаанд оролцдог байв. Би Залуу Эмэгтэйчүүдийн үйл ажиллагаануудад итгэлтэйгээр оролцож чаддаггүй, ням гарагуудад гэрийн даалгавраа хийж дуусгахыг хичээн, бөөн дарамтанд орсон хүн л байдаг байв. Хөгжим тоглох, сургуулийн сонин гаргах нь зугаатай зүйл байхаа больж, ажил болж хувирав.

Ахлагч Өүксийн хэлсэн үг цагийн хуваариа нухацтай эргэн харахад хүргэсэн юм. Миний хийдэг байсан үйл ажиллагаанууд сайн ч дэндүү олон байлаа. Хамгийн сайнуудыг нь сонгох хэрэгтэй боллоо. Аль үйл ажиллагаануудыг нь орхих хэрэгтэйг шийдэхийг хичээх үед би Есүс Христийн сайн мэдээ юу юунаас чухал хамгийн сайн, эн тэргүүний зүйл болохыг ойлгосон юм. Би залбирал, судраа судлахыг жагсаалтын эхэнд

тавьснаас хойш миний амьдрал илүү амар хялбар болсон.

Их Эзэн юуг бүхнээс түрүүнд хийгээсэй гэж биднээс хүсдэг тэр зүйлийг бид хийхэд бусад зүйлс байх ёстой газраа байх болно гэдгийг Ахлагч Өүкс заасан юм. Хэрэв би тоглохынхоо өмнө түүнчлэн гэрийн даалгавраа хийхээсээ өмнө ч гэсэн судраа судлах юм бол чухал зүйл бүхэн хийгдсэн байх болно. Өнгөрсөн хойно нь Их Эзэнээ санахын оронд амьдралаа Түүний эргэн тойронд суурилуулснаар миний амьдрал амар амгалан, амжилт бүтээлээр дүүрэн болсон юм.

Одоо би ерөнхий чуулган дээр өгсөн зөвлөгөөнүүдийг маш анхааралтай сонсдог болсон!

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Би ерөнхий чуулганаас хариултуудыг олж чадна

Ерөнхий чуулганы өмнө зарим асуултынхаа талаар бодох юм бол Их Эзэн Өөрийн бошиглогчид, төлөөлөгчдөөр дамжуулан та нартай ярьж чадна

гэдгийг Ерөнхийлөгч Угдорф заасан юм.

1. Гэр бүл эсвэл ангиараа бие даан эсвэл хамтдаа юуг сурч мэдэх хэрэгтэйг ярилц. (Жишээлбэл: Би гэрчлэлээ хэрхэн бэхжүүлэх вэ? Сургууль дээрх асуудлаа би хэрхэн шийдэх ёстой вэ?) Цаасан дээр эсвэл тэмдэглэлийн дэвтэртээ асуултуудаа бич.
2. Чуулган болохын өмнөх долоо хоногуудад эдгээр асуултуудын талаар бодож, залбир.
3. Чуулганы үеэр анхааралтай сонс (тэмдэглэл хөтлөх нь тустай). Тэгээд Их Эзэн—Сүмийн удирдагчдаар дамжуулан—асуултуудад чинь хэрхэн хариулсныг бич.
4. Бас өөр нэг цаасан дээр сурч мэдсэн зүйлээ амьдралд хэрхэн хэрэгжүүлж байгаагаа зурж болно.

© 2011 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/10 Орчуулгын зөвшөөрөл: 6/10. *First Presidency Message, September 2011* -ийн орчуулга. Mongolian. 09769 363



Итгэл • Гэр бүл • Халамж

Сүнслэг байдлыг өсгөснөөр гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэх нь

Энэ материалыг судлаад, гэрээр нь очиж заадаг эгч нартайгаа энэ талаар харилцан ярилц. Эгч нарыг хүчирхэгжүүлж, Нийгмийн Халамжийн Бүлгийг амьдралынхаа идэвхтэй хэсэг болгоход туслах асуултуудыг асуу.

Нийгмийн Халамжийн Бүлгийн Ерөнхий ерөнхийлөгч Жюли Б.Бек хэлэхдээ: “Бурханы охидын үнэ цэнийн тухай миний гэрчлэл асар их өссөн. . . . Хувийн зөв шударга байдал болон итгэлээ өсгөх, хүчирхэг гэр бүл, гэр орныг бий болгохоос илүү чухал хэрэгцээ хэзээ ч байгаагүй, байх ч үгүй” гэв.

Эгч нар хувийн илчлэлтээ үйлдэл болговол бат бөх гэр бүлийг бий болгож чадна. “Хувийн илчлэлт хүлээн авч, үүнийг үйлдэл болгох чадварыг сайжруулах нь энэ амьдралд эзэмшиж болох цорын ганц хамгийн чухал чадвар юм” хэмээн Бек эгч цааш нь хэлжээ. “Их Эзэний Сүнсийг олж авах үйл явц Сүнсийг байлгах хүслээс эхэлдэг бөгөөд зохистой байдлын тодорхой төвшинг шаарддаг. Зарлигуудыг сахьж, наманчлан, баптисмын гэрээнүүдээ шинэчлэх нь Их Эзэний Сүнсийг өөрсөдтэйгөө байнга байлгах адислал өөд хөтөлдөг. Ариун сүмд гэрээнүүдийг хийж, сахих нь эмэгтэйчүүдийн амьдралд сүнслэг хүч чадлыг нэмдэг. Судрууд нь илчлэлтийг хүлээн авахад тусалдаг учраас хүндхэн асуултуудын олон хариулт судруудыг уншихад ирдэг. . . . Өдөр тутмын залбирал нь Их Эзэний Сүнсийг өөрсөдтэйгөө байлгахад онцгой чухал юм.”¹

Бид мөн гэр бүлийнхэндээ Тэнгэрлэг Эцэгийн мөнхийн

төлөвлөгөөг ойлгоход нь тусалснаар тэдний сүнслэг байдлыг бэхжүүлдэг. “Хүүхдүүдийнхээ мөнхийн үүрэг хариуцлагад тэднийг сүнслэгээр илүү сайн бэлтгэхийн тулд бид юу хийж чадах вэ?” гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Расселл Баллард асуужээ. “Хамгийн оновчтой хариулт нь: Тэдэнд сайн мэдээний зарчмуудын дагуу хэрхэн амьдрахыг заах явдал болов уу.” Ийнхүү тэдэнд заах нь өдөр тутмын залбирал, судруудыг судлах, гэр бүлийн хоолны цаг болон долоо хоног бүрийн гэр бүлийн үдэш, Сүмдээ явахаар дамжин хэрэгждэг юм. Ахлагч Баллард: “Бид өдөр бүр, яг одоо мөнх амьдралдаа бэлтгэдэг. Хэрэв бид мөнх амьдралд бэлтгээгүй бол ямар нэгэн дулимаг, магадгүй бүр дэндүү дулимаг зүйлд бэлтгэж байна гэсэн үг” гэж тайлбарлав.²

Судруудаас

Сургаалт Үгс 22:6; 1 Иохан 3:22; Сургаал ба Гэрээ 11:13–14; 19:38; 68:25

Бидний түүхээс

Бошиглогч Иосеф Смит 1842 оны дөрөвдүгээр сард Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаан дээр эгч нар өөрсдийнхөө авралыг эрэлхийлэх чухал үүрэгтэйг тэдэнд заажээ. Тэрбээр хэлэхдээ “[Миний]

зааврын дараа та нар нүглийнхээ төлөө хариуцлага хүлээх болно. Өөрсдийгөө аврахын тулд Тэнгэрлэг Эцэгийн өмнө алхана гэдэг хүсүүштэй бөгөөд нэр төрийн асуудал юм. Бид Бурханы өмнө өөрсдийгөө аврах боломжийг бидэнд олгогч Их Эзэний өгсөн гэрэл ба мэргэн ухааныг өөртөө хөгжүүлэх үүрэгтэй.”³ Тэрээр тэдэнд зөв шударга, ариун хүмүүс болж, ариун сүмийн ёслол болон гэрээнүүдэд бэлтгэхийг заасан юм.

Эшлэл

1. Жюли Б.Бек, “And upon the Handmaids in Those Days Will I Pour Out My Spirit,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 10, 11
2. М. Расселл Баллард, “Spiritual Development,” *Ensign*, 1978 оны 11-р сар, 65, 66
3. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 355.

Би юу хийж чадах вэ?

1. Би сүнслэг байдал болон бие даах чадварыг хөгжүүлэхэд нь эгч нартаа хэрхэн тусалж чадах вэ?
2. Ариун Сүнсийг таньж, түүнд хариулах чадвараа би хэрхэн хөгжүүлэх вэ?

Нэмэлт мэдээллийг www.reliefsoociety.lds.org-аас үзнэ үү.